



## БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

**АУДИТЫН НЭР:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэл

**АУДИТЫН КОД:** УАГ-НАГ-/2017/04-НА-БАГ-03



*Аймгийн сонгуулийн хороо хууль, журмын зарим заалтыг  
мөрдөж ажиллаагүй байна.*

*Баянхонгор хот  
2017.07.31*

## АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Баянхонгор аймаг дахь  
Төрийн аудитын газар

Газрын дарга, тэргүүлэх  
аудитор

Б.Мөнхбат

Аудитын менежер

Д.Цэцэгмаа

Ахлах аудитор

Б.Должмаа

Аудитор

Б.Цэрэнчимэд

Аудитор

Б.Азбаяр

2017 оны 07 дугаар сар

Уг тайланг Баянхонгор аймаг  
дахь Төрийн аудитын газрын

Цахим хуудаснаас үзнэ үү:

[www.audit.bayankhongor.mn](http://www.audit.bayankhongor.mn)

Аудитын тайлан, дүгнэлттэй  
холбоотой асуудлаар нэмж  
тодруулах, асууж лавлах зүйл  
байвал 70442584, 70442424  
дугаарын утсаар харилцана уу.

Хаяг: Баянхонгор сум, Номгон  
1-р баг, Төр захиргааны ордон  
3-р давхар

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ 1

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН..... 2

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй,  
стандартын мэдээгдэл ..... 2

НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН..... 5

Бүлэг 1. Аймгийн сонгуулийн хороо, сумын хороодууд  
зарим зардлыг зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулж,  
журмыг зөрчсөн байна..... 5

1.1 Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн батлагдсан  
төсвийг зохих аргачлалын дагуу төлөвлөсөн эсэх асуудлыг  
аймгийн Сонгуулийн хорооны материалаас үзэх боломжгүй  
байна. .... 5

1.2. Сумдын сонгуулийн хороонд 10 төрлийн зардал  
хуваарилахаас 4 төрлийн зардлыг хуваарилалгүй аймгийн  
сонгуулийн хороо нэгдсэн журмаар олгож журмыг зөрчжээ.  
..... 5

1.3. Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардлын 2088,8  
мянган төгрөгийн үлдэгдлийг СЕХ-д эргүүлэн  
төвлөрүүлээгүй, ээлжит сонгуулийн зардлаас дахин  
сонгуулийн зардалд 3,0 сая төгрөгийг гүйлгэн зарцуулж  
журмыг зөрчсөн байна... 7

Бүлэг 2. Аймгийн сонгуулийн хороо анхан шатны  
баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаагүй ба 12  
сумын сонгуулийн хорооны тайланг акт үйлдэж  
хүлээж аваагүй байна. .... 10

2.1. Аймгийн Сонгуулийн хороо болон зарим сумын  
сонгуулийн хороо сонгуулийн зардлын гүйцэтгэлийн  
тайланг буруу тайлагнасан байна. 10

2.2. Аймгийн сонгуулийн хороо хяналтыг бүрэн  
хэрэгжүүлж ажиллаагүйгээс сумын сонгуулийн хорооны  
зардлын гүйцэтгэлийн тайланг журамд заасны дагуу бүрэн  
хүлээн аваагүй, зарим сум тайланг хугацаа хоцроож  
ирүүлсэн байна. .... 12

*ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ*

|                                   |                                                                                                                                             |
|-----------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| МУ<br>ҮАГ<br>НАГ<br>АДБОУС<br>СЕХ | Монгол Улс<br>Үндэсний аудитын газар<br>Нийцлийн аудитын газар<br>Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт<br>Сонгуулийн ерөнхий хороо |
|-----------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

#### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Улсын Их хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоолыг үндэслэн 2017 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэв.

#### Аудитын зорилт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтыг шалгаж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилж, зарцуулсан эсэх
- Сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьсан эсэх

#### Аудитын хамарсан хүрээ

Аудитад МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит болон дахин сонгуулийн хугацаанд ажилласан аймгийн Сонгуулийн 1 хороо, сумын сонгуулийн 20 хороо, санал авах 105 байрыг хамруулж, улсын төсвөөс Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд олгосон хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт, түүний гүйцэтгэл, хяналт, тайлагналыг хамруулав.

#### Аудитын арга зүй

ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн арга зүйн дагуу аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4100, Төрийн хяналт, шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан аймгийн Сонгуулийн хорооноос авсан мэдээлэл, баримт материал, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага, хийх, судалгаа гаргуулах, дүн, шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглаж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан болно.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

### **Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт**

Аудитад дараах хууль эрхийн актууд болон шаардлагатай бусад баримт бичгийг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Сонгуулийн тухай хууль, Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоол, Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан бусад дүрэм, журам, заавар, холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандартыг ашиглав.

### **Үндсэн мэдээлэл**

УИХ-аас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр шинэчлэн баталсан Сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.3, 16.6 дахь заалтын дагуу Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдөр явуулахаар товлон зарлажээ.

Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь заалтаар сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын төрлийг заасан байна.

СЕХ-ны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам”-ыг баталж, тус журамд СЕХ-ны 2016 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 265 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Сонгуулийн ерөнхий хороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулиар Баянхонгор аймгийн сонгуулийн 1 хороо, сумын сонгуулийн 20 хороо, 105 хэсгийн хороодод 415,1 сая төгрөгийн зардлыг улсын төсвөөс хуваарилсан байна.

Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 5 дахь заалтын дагуу Сонгуулийн ерөнхий хороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн анхан шатны санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч олонхын санал аваагүй тул хоёр дахь санал хураалтыг 2017 оны 07 дугаар сарын 07-нд явуулах тогтоолыг 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдөр гаргаж, сонгуулийн зардалд Баянхонгор аймагт улсын төсвөөс 154,8 сая төгрөг хуваарилжээ.

СЕХ-ны 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 10 тоот тогтоолоор Баянхонгор аймгийн сонгуулийн хороог аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Дашцэрэнгээр ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, аймгийн сонгуулийн хорооны даргын 2017 оны 01 тоот захирамжаар аймгийн сонгуулийн хорооны санхүүгийн

ажилтнаар Э.Амарбаясгалан, архив, бичиг хэргийн ажилтнаар Д.Мягмарыг томилж, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу 5 даамал ажиллаж, аймгийн сонгуулийн хороонд нийт 16 ажилтан ажиллажээ.

**Аудитын хугацаа, аудит хийхэд гарсан хүндрэл бэрхшээл**

Аудитын дэд төлөвлөгөөг 2017 оны 07 дугаар сарын 20-нд батлуулж, аудитын нээлтийг 07 дугаар сарын 24-нд хийж объект дээрх ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн боловч аймгийн сонгуулийн хорооны дарга Ц.Дашцэрэн эзгүй байсан бөгөөд 07 дугаар сарын 27-ны өдөр ирж, аудитын талаар танилцуулсан.

Санхүүгийн баримтанд даргын гарын үсэг дутуу, баримт материалыг үдээгүй гэсэн шалтгааны улмаас аймгийн сонгуулийн хорооны санхүүгийн баримтыг шаардсан хугацаанд ирүүлээгүй, ирсэн нь шаардлага хангахгүй, дүн зөрүүтэй байсан, аймгийн сонгуулийн хорооны санхүүгийн баримтыг 07 дугаар сарын 28-ны өдөр ирүүлсэн зэргээс аудитын дэд төлөвлөгөөний хугацааг мөрдөх боломжгүй болж хугацаа алдахад хүргэж байлаа.

Аудитын тайланг 2017 оны 08 дугаар сарын 01-ны өдөр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, ҮАГ-ын Нийцлийн аудитын газарт хүргүүлэв.

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН

МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилж, зарцуулсан эсэх

**Бүлэг 1. Аймгийн сонгуулийн хороо, сумын хороодууд зарим зардлыг зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулж, журмыг зөрчсөн байна.**

*1.1 Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн батлагдсан төсвийг зохих аргачлалын дагуу төлөвлөсөн эсэх асуудлыг аймгийн Сонгуулийн хорооны материалаас үзэх боломжгүй байна.*

СЕХ төсвийн төсөл боловруулахдаа СЕХ-ны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам”-ын 2.1<sup>1</sup>-т заасны дагуу аймгаас санал аваагүй байгаа нь сонгуулийн зардлыг ямар үзүүлэлтээр, хэрхэн төлөвлөснийг орон нутагт үзэх боломжгүй байна.

Харин сумын сонгогчийн тоог 105 санал авах байр тус бүрээр авч үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2<sup>2</sup> -т заасны дагуу сумын хүн амын тоонд үндэслэж төлөвлөжээ.

*1.2. Сумдын сонгуулийн хороонд 10 төрлийн зардал хуваарилахаас 4 төрлийн зардлыг хуваарилалгүй аймгийн сонгуулийн хороо нэгдсэн журмаар олгож журмыг зөрчжээ.*

УИХ-аас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр шинэчлэн баталсан Сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1<sup>3</sup>, 16.3<sup>4</sup>, 16.6<sup>5</sup> дахь заалтыг үндэслэн Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдөр явуулахаар товлон зарласны дагуу Баянхонгор аймагт сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулжээ.

Гэвч Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн анхан шатны санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч олонхын санал аваагүй тул

<sup>1</sup> “СЕХ нь сонгуулийн батлагдсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байр, тэдгээрт ажиллах гишүүдийн тоог харгалзан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна”

<sup>2</sup> “Нэг хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төвд 2500-аас дээшгүй, нийслэлийн дүүрэгт 3000-аас дээшгүй сонгогчтой байна”

<sup>3</sup> “Ээлжит сонгуулийг санал авах өдрөөс 65-аас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурал товлон зарлана”

<sup>4</sup> “Ээлжит сонгуулийн санал авах өдрийг санал авах өдрөөс 150-иас доошгүй хоногийн өмнө тогтооно”

<sup>5</sup> “Гадаад улсад суугаа иргэдээс санал авах өдөр /цаашид “гадаадад санал авах өдөр” гэх/-ийг Улсын Их Хурал тогтоох бөгөөд уг санал авах хугацаа нь гурав хүртэл өдөр байж болно”




Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5<sup>6</sup> дахь заалтын дагуу Сонгуулийн ерөнхий хороо хоёр дахь буюу дахин санал хураалтыг 2017 оны 07 дугаар сарын 07-нд явуулах тогтоолыг 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдөр гаргаж, тухайн өдөр дахин санал хураалтыг орон нутагт зохион байгуулжээ.

Сонгуулийн ерөнхий хороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулиар Баянхонгор аймгийн сонгуулийн 1 хороо, сумын сонгуулийн 20 хороо, 105 хэсгийн хороод /санал авах байр/ ажиллахаар баталж, Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2<sup>7</sup> дахь заалтын дагуу улсын төсвөөс Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг Баянхонгор аймагт зохион байгуулах зардалд 415,1 сая, дахин сонгуулийг зохион байгуулах зардалд 154,8 сая төгрөгийг хуваарилсан байна.

Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардлыг хуваарилах тухай 4 удаа, дахин сонгуулийн зардлыг хуваарилах тухай 2 удаагийн зөвлөмж, аргачлалыг СЕХ-ноос аймгийн сонгуулийн хорооны даргад ирүүлсний дагуу сумдын сонгуулийн хороодод зардлыг хуваарилжээ.

Гэвч СЕХ-ны 2016 оны 04 тоот тогтоолоор баталсан журмын 2.3-т заасны дагуу аймгийн сонгуулийн хороо сумдын сонгуулийн хороонд 10 зардал хуваариалахаас томилолт, сургалт, сонгуулийн бичиг баримт болон техник хэрэгслийг аймгийн сонгуулийн хорооноос авах, хүлээлгэн өгөх зардал, болзошгүй зардал зэргийн 4 зардлыг сумдад хуваарилалгүй аймгийн сонгуулийн хорооноос олгосон байна.



Ерөнхийлөгчийн ээлжит болон дахин сонгуулийн зардалд улсын төсвөөс хуваарилсан 570.0 сая төгрөгийн 63.8 хувь буюу 364.0 сая төгрөгийг сумдын сонгуулийн хороодод хуваарилсан байна.

<sup>6</sup> “Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхийн санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. Дахин санал хураалтаар сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана”

<sup>7</sup> “38.2.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, орон нутгийн хурлын сонгуулийн доор дурдсан сонгуулийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.”



1.3. Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардлын 2088,8 мянган төгрөгийн үлдэгдлийг СЕХ-д эргүүлэн төвлөрүүлээгүй, ээлжит сонгуулийн зардлаас дахин сонгуулийн зардалд 3,0 сая төгрөгийг гүйлгэн зарцуулж журмыг зөрчсөн байна.

СЕХ-ны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам”-ын 3.5<sup>8</sup>-т заасны дагуу аймаг, сумын сонгуулийн хорооны дансыг Сангийн яам нээсэн байна. Мөн журмын 3.1<sup>9</sup>-т заасны дагуу аймгийн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Дашцэрэн, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн ажилтан Э.Амарбаясгалан нар зурж, хөрөнгийг захиран зарцуулжээ.

МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит болон дахин сонгуулийн зардлын гүйцэтгэлийг зардлын нэр төрлөөр харуулбал:

| №  | Зардлын нэр                                                                                                                                                                          | Ээлжит сонгууль |           |          | Дахин сонгууль |           |          | Нийт дүн   |           |          |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|-----------|----------|----------------|-----------|----------|------------|-----------|----------|
|    |                                                                                                                                                                                      | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл | Үлдэгдэл | Төлөвлөгөө     | Гүйцэтгэл | Үлдэгдэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Үлдэгдэл |
| 1  | Сонгуулийн бичиг баримт болон техник хэрэгслийг сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах, тээвэрлэх зардал                                            | 18829           | 18693     | 136.1    | 17336          | 13054     | 4282     | 36165      | 31747     | 4418     |
| 2  | Тогтоол, протокол, албан бичгийн хэвлэмэл хуудас, маягт хэвлүүлэх зардал                                                                                                             | 250             | 10        | 240.0    |                |           | 0        | 250        | 10        | 240      |
| 3  | Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал                                                                                                                   | 4410            | 4410      | 0.0      | 4410           | 4410      | 0        | 8820       | 8820      | 0        |
| 4  | Дүн мэдээ дамжуулах зардал                                                                                                                                                           | 6300            | 6300      | 0.0      | 6300.0         | 6300      | 0        | 12600      | 12600     | 0        |
| 5  | Санал авах байр бэлтгэх тохижуулах зардал                                                                                                                                            | 21000           | 21000     | 0.0      |                |           | 0        | 21000      | 21000     | 0        |
| 6  | Сургалтын зардал                                                                                                                                                                     | 20731           | 19506     | 1224.7   |                |           | 0        | 20731      | 19506     | 1225     |
| 7  | Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал | 235714          | 235268    | 445.6    | 111320.0       | 110356    | 964      | 347034     | 345624    | 1410     |
| 8  | Бичиг хэргийн зардал                                                                                                                                                                 | 23700           | 23699     | 0.8      | 2075.0         | 2040      | 35       | 25775      | 25739     | 36       |
| 9  | Шуудан холбооны зардал                                                                                                                                                               | 22700           | 22657     | 42.6     | 2600.0         | 2556.2    | 44       | 25300      | 25214     | 86       |
| 10 | Унааны зардал                                                                                                                                                                        | 41500           | 41500     | 0.0      | 10800.0        | 10417.2   | 383      | 52300      | 51917     | 383      |
| 11 | Албан томилолтын зардал                                                                                                                                                              | 5516            | 5517      | -1.0     |                |           | 0        | 5516       | 5517      | -1       |
| 12 | Үнэмлэх хэвлэх зардал                                                                                                                                                                | 0               | 0         | 0.0      |                |           | 0        | 0          | 0         | 0        |
| 13 | Сурталчилгааны зардал                                                                                                                                                                | 10500           | 10500     | 0.0      |                |           | 0        | 10500      | 10500     | 0        |
| 14 | Болзошгүй зардал                                                                                                                                                                     | 3000            | 3000      | 0.0      |                |           | 0        | 3000       | 3000      | 0        |
| 15 | Бусад зардал                                                                                                                                                                         | 1000            | 1000      | 0.0      |                |           | 0        | 1000       | 1000      | 0        |
|    | Дүн                                                                                                                                                                                  | 415150          | 413061    | 2088.8   | 154841.0       | 149133.4  | 5707.6   | 569991.0   | 562194.6  | 7796.4   |

Баянхонгор аймагт МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн ээлжит сонгуулийг зохион байгуулах зардалд 415150,0 мянган төгрөг хуваарилагдсанаас гүйцэтгэлээр 413061,0 мянган төгрөг зарцуулж, 2088,8 мянган төгрөг хэмнэсэн байхад үлдэгдлийг 2017 оны 07 дугаар сарын 26-ны дотор СЕХ-ны дансанд төвлөрүүлээгүй байгаа нь СЕХ-ны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд

<sup>8</sup> “СЕХ нь сонгуулийн хороодын зардлын дансыг Сангийн яамны Төрийн сангийн газарт нээлгэн, сонгууль дууссаны дараа зохих журмын дагуу хаалгана”

<sup>9</sup> “Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс, салбар комиссын дарга нь тухайн сонгуулийн хорооны зардлын дансны 1-р гарын үсгийг, томилогдсон нягтлан бодогч 2-р гарын үсгийг зурж, энэхүү журмын 2.2, 2.3 дахь хэсэгт заасан хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна”

хяналт тавих, тайлан гаргах журам"-ын 3.1<sup>10</sup> дахь заалтыг зөрчсөн тул 2017 оны 07 дугаар сарын 31-ны дотор СЕХ-ны дансанд төвлөрүүлэх зөвлөмж хүргүүлэв.

Баянхонгор аймагт МУ-ын Ерөнхийлөгчийн дахин сонгуулийг зохион байгуулах зардалд 154841,0 мянган төгрөгөөс хуваарилагдсанаас гүйцэтгэлээр 149133,4 мянган төгрөг олгож, аймгийн сонгуулийн хорооны дансанд 5707,6 мянган төгрөг үлдэгдлээр байгааг 2017 оны 08 дугаар сарын 07-ны дотор СЕХ-ны дансанд төвлөрүүлэх зөвлөмжийг аймгийн сонгуулийн хороонд хүргүүлэв.

МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардлаас Баян-Өндөр сумын сонгуулийн хороонд хуваарилсан зардлаас ажиллаагүй 2 ажилтны хоолны зардлын 100,0 мянга, ажиллаагүй 2 зохион байгуулагчийн урамшууллын 345,6 мянга, нийт 445,6 мянган төгрөг, дахин сонгуулийн зардлаас Жаргалант сумын сонгуулийн хороо унааны зардлын хэмнэлтийн 382,8 мянга, Баян-Өндөр сумын сонгуулийн хороо хоолны зардлын 36,0 мянга, нийт 418,8 мянган төгрөгийг аймгийн сонгуулийн хорооны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулиар аймгийн Сонгуулийн хороонд 16, 20 сумын сонгуулийн хороонд 104, 20 сумын 105 санал авах байранд 912, нийт **928**, дахин сонгуулиар нийт **919** сонгуулийн байгууллагын ажилтан ажиллажээ. Энэ нь ээлжит сонгуулиар ажилласан хүмүүсээс Баян-Өндөр сум 2, Богд сум 2, Баян-Овоо сум 5 хүн ажиллаагүйтэй холбоотой байна.

Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд ажилласан гишүүдийг хүснэгтээр харуулбал:

| №  | Сумдын нэр  | Ээлжит сонгууль       |                           |                         |                   |        | Дахин сонгууль                       |                                      |
|----|-------------|-----------------------|---------------------------|-------------------------|-------------------|--------|--------------------------------------|--------------------------------------|
|    |             | Санал авах байрны тоо | Сонгуулийн хорооны гишүүн | Санал авах байрны       |                   |        | Сонгуулийн байгууллагын нийт ажилтан | Сонгуулийн байгууллагын нийт ажилтан |
|    |             |                       |                           | Ахлах зохион байгуулагч | Зохион байгуулагч | Даамал |                                      |                                      |
| 1  | Галуут      | 6                     | 5                         | 6                       | 24                | 7      | 42                                   | 42                                   |
| 2  | Баян-Овоо   | 4                     | 5                         | 4                       | 16                | 5      | 30                                   | 25                                   |
| 3  | Эрдэнэцогт  | 6                     | 5                         | 6                       | 36                | 7      | 54                                   | 54                                   |
| 4  | Бууцагаан   | 6                     | 5                         | 6                       | 36                | 7      | 54                                   | 54                                   |
| 5  | Жинст       | 5                     | 5                         | 5                       | 20                | 6      | 36                                   | 36                                   |
| 6  | Богд        | 6                     | 5                         | 6                       | 36                | 7      | 54                                   | 52                                   |
| 7  | Баянлиг     | 5                     | 5                         | 5                       | 30                | 6      | 46                                   | 46                                   |
| 8  | Баянговь    | 4                     | 5                         | 4                       | 24                | 5      | 38                                   | 38                                   |
| 9  | Гурванбулаг | 5                     | 5                         | 5                       | 30                | 6      | 46                                   | 46                                   |
| 10 | Жаргалант   | 4                     | 5                         | 4                       | 24                | 5      | 38                                   | 38                                   |
| 11 | Заг         | 4                     | 5                         | 4                       | 24                | 5      | 38                                   | 38                                   |
| 12 | Баацагаан   | 7                     | 5                         | 7                       | 28                | 8      | 48                                   | 48                                   |

<sup>10</sup> "Сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор сонгуулийн зардлын үлдэгдлийг СЕХ-ны дансанд эргүүлэн төвлөрүүлнэ"

|                                            |            |            |            |            |            |            |            |            |
|--------------------------------------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|
| 13                                         | Бөмбөгөр   | 4          | 5          | 4          | 24         | 5          | 38         | 38         |
| 14                                         | Өлзийт     | 6          | 7          | 6          | 36         | 7          | 56         | 56         |
| 15                                         | Хүрээмарал | 5          | 5          | 5          | 30         | 6          | 46         | 46         |
| 16                                         | Баянбулаг  | 4          | 5          | 4          | 24         | 5          | 38         | 38         |
| 17                                         | Шинэжинст  | 4          | 5          | 4          | 16         | 5          | 30         | 30         |
| 18                                         | Баянцагаан | 5          | 5          | 5          | 30         | 6          | 46         | 46         |
| 19                                         | Баян-Өндөр | 4          | 5          | 4          | 24         | 5          | 38         | 36         |
| 20                                         | Баянхонгор | 11         | 7          | 11         | 66         | 12         | 96         | 96         |
| <b>СУМЫН ДҮН</b>                           |            | <b>105</b> | <b>104</b> | <b>105</b> | <b>578</b> | <b>125</b> | <b>912</b> | <b>903</b> |
| <b>Баянхонгор аймгийн сонгуулийн хороо</b> |            | <b>0</b>   | <b>11</b>  | <b>0</b>   | <b>0</b>   | <b>5</b>   | <b>16</b>  | <b>16</b>  |
| <b>АЙМГИЙН ДҮН</b>                         |            | <b>0</b>   | <b>115</b> | <b>105</b> | <b>578</b> | <b>130</b> | <b>928</b> | <b>919</b> |

Аймгийн сонгуулийн хорооны 14 гишүүнд дахин сонгуулийн хугацаанд ажилласан хоолны зардалд 280,0 мянган төгрөгийн зардал олгохдоо татварт 28,0 мянган төгрөг суутган тооцсон атлаа төсөвт төвлөрүүлээгүй байгаа тул нөхөн төлүүлэх зөвлөмжийг аймгийн сонгуулийн хороонд хүргүүлэв.

СЕХ-ны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам”, Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын тухай СЕХ-ноос ирүүлсэн тайлбар бичгийг мөрдөөгүйгээс дараахь үргүй зардлууд гарсан байна. Тухайлбал:

*СЕХ-ны 2017 оны 06 дугаар сарын 13-ний өдрийн 199 тоот албан бичгээр “Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардлын дүн мэдээ хүлээлгэн өгөх зардалд 1 сумаас 2 хүнээр тооцож, 1 өдрийн томилолтод 29,0 мянган төгрөг олгох” тайлбарыг ирүүлсэн байхад Жаргалант, Бөмбөгөр, Баацагаан, Богд, Баянговь, Баянлиг, Жинст, Өлзийт, Гурванбулаг зэрэг 9 сумаас 3 хүн ирж, тэдгээрийн томилолтод 261,0 мянган төгрөгийг олгосон;*

*Баацагаан, Шинэжинст, Гурванбулаг сумдын санал тоолох төхөөрөмж эвдэрсэн тул аймгийн сонгуулийн хорооны мэдээлэл технологийн баг тухайн сумдаар засвар үйлчилгээ хийж явахдаа нэг суманд гарах зардлыг 950,0 мянган төгрөгөөр тооцож, 2850,0 мянган төгрөгийг хяналтгүй зарцуулсан;*

*Аймгийн Нисэх буудлаас Улсын бүртгэлийн газарт Улаанбаатар хотоос ирсэн санал тоолох төхөөрөмжийг хүргэж өгөх зардалд 730,0 мянган төгрөг олгосон;*

*МУ-ын Ерөнхийлөгчийн дахин сонгуулийн зохион байгуулах зардлыг хэрхэн хуваариалах тухай СЕХ-ноос ирүүлсэн 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн тайлбар бичигт “Саналын хуудсыг СЕХ-оос авахад 3 хүнд 2 өдрийн томилолтод өдрийн 35,5 мянган төгрөгөөр тооцож, унааны зардлыг Улаанбаатар хотоос Баянхонгор хүртэлх 640 км-д 1 км тутамд 500 төгрөг олгохоор тайлбар ирүүлсэн*

байхад 2 автомашин явж, шатахууны зардалд 640,0 мянган төгрөгийг үргүй зарцуулсан;

Сонгуулийн байгууллагын ажилтнуудад гэрчилгээ олгох сургалтаар ирсэн хүмүүсийг Шаргалжуут рашаан сувилалд амрах зардалд 251,0 мянга, хоолны зардалд 371,5 мянга, нийт 622,5 мянган төгрөгийг олгож зориулалт бусаар зарцуулсан;

Ерөнхийлөгчийн сонгуулийн шахатууны зарцуулалтыг зам явсан хуудастай тулган шалгахад 148,3 мянган төгрөгөөр дутагдуулсан байгаа тул зөрчлийг арилгах зөвлөмжийг хүргүүлэв.

Аймгийн сонгуулийн хорооны санхүүгийн ажилтны СЕХ-д сонгуулийн зардлын тайлан хүлээлгэж өгөөгүй байгаа тул томилолтын 35,5 мянга, унааны 640,0 мянга, нийт 711,0 мянган төгрөгийн зарцуулалтын баримт байхгүй учир холбогдох анхан шатны баримтыг санхүүгийн баримтанд бүрдүүлж, зөрчлийг арилга зөвлөмжийг аймгийн сонгуулийн хороонд хүргүүлээ.

Сонгууль, зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьж ажилласан эсэх?

**Бүлэг 2. Аймгийн сонгуулийн хороо анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаагүй ба 12 сумын сонгуулийн хорооны тайланг акт үйлдэж хүлээж аваагүй байна.**

*2.1. Аймгийн Сонгуулийн хороо болон зарим сумын сонгуулийн хороо сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг буруу тайлагнасан байна.*

СЕХ-оос ирүүлсэн зөвлөмжийн дагуу санхүүгийн бүртгэлийг тусгай программ ашиглаагүй, Microsoft office excel программ дээр бүртгэлийг хөтөлсөн байна.

СЕХ-ны 2016 оны 04 тоот тогтоолоор баталсан журмын 2 дугаар хавсралтаар баталсан маягтаар аймгийн сонгуулийн хорооны ээлжит сонгуулийн нэгдсэн тайлангийн гүйцэтгэлийг 854,3 мянга, дахин сонгуулийн зардлын нэгдсэн тайлангийн гүйцэтгэлийг 38,5 мянган төгрөгөөр зөрүүтэй гаргасан байсныг аудитын явцад залруулав.

СЕХ-ны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам”-ын 4.3-т заасны дагуу Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг сонгуулийн санал хураалт дууссанаас хойш 3 хоногийн дотор ирүүлэх ёстой боловч СЕХ-ноос аймаг, нийслэлийн

сонгуулийн хороодод 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдөр явуулсан 252 тоот албан бичгийн 15-т "... Сум, дүүргийн сонгуулийн хороо хоёр дахь санал хураалт дууссаны дараа 2 тусдаа тайлан, анхан шатны баримтаа бэлтгэж, аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүлээлгэж өгөх" гэсэн чиглэл өгсөн. Мөн Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн байгууллагад ажилласан ажилтнуудад олгох хоол, урамшууллын зардлын санхүүжилт 2017.06.22-ны өдөр Төрийн сангийн дансанд орсон хэдий ч санхүүжилтийн эрхийг нээгээгүй, СЕХ-ны ахлах реферант н.Оюунгэрэл "урамшууллын зардлаас эхний ээлжинд хоолны зардлын эрхийг нээнэ, сонгууль дууссаны дараа урамшууллын зардлын эрхийг нээнэ" гэсэн чиглэл өгсөн учир сонгуулийн байгууллагын нэг ажилтанд 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдөр 100,0 мянган төгрөг олгож, үлдэгдэл санхүүжилтийг 07 дугаар сарын 06-ны өдөр сумдын сонгуулийн хороонд шилжүүлж, дахин сонгууль явагдсаны дараа сумдаас сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн баримтыг хүлээн авчээ.

Аймгийн сонгуулийн хорооны санхүүгийн ажилтан Э.Амарбаясгалан журмын СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 4.6<sup>11</sup> дахь заалтыг хэрэгжүүлж, сумдын сонгуулийн хорооны тайланг хянаж шалгаагүйгээс дараахь сумдын сонгуулийн хороо зардлын гүйцэтгэлийн тайланг буруу гаргасан байна. Үүнд:

*Баянхонгор сум, Гурванбулаг, Бууцагаан сумдын сонгуулийн хороо ээлжит сонгуулийн урамшууллын зардлыг дахин сонгуулийн зардлын тайланд оруулж тайлагнасан;*

*Жаргалант сумын сонгуулийн хороо дахин сонгуулийн зардалд хуваарилагдсан унааны зардлаас 382,8 мянган төгрөг хэмнэж, хэмнэлтийг аймгийн сонгуулийн хорооны дансанд төвлөрүүлсэн атлаа зардлын тайланд үлдэгдлээр тайлагнасан;*

*Галуут сумын сонгуулийн хороо ээлжит сонгуулийн зардлын тайланд зарим зардлын төлөвлөгөөг буруу илэрхийлсэн;*

*Өлзийт сумын сонгуулийн хороо дахин сонгуулиар 2252,0 мянган төгрөг хуваарилагдаж, түүнийг бүрэн зарцуулсан байхад сонгуулийн зардлын тайланг 426,8 мянган төгрөгөөр дутуу буюу 1825,2 мянган төгрөгөөр тайлагнасан;*

*Баян-Өндөр сумын сонгуулийн хороо ээлжит болон дахин сонгуулийн тайланг нэгтгэж гаргасан зэргээр СЕХ-ноос ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.*

<sup>11</sup> "Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нягтлан бодогч сум, дүүргийн сонгуулийн хорооноос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авч, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны санхүүгийн анхан шатны баримтын хамт архивын нэгж болгон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын архивт албан ёсоор хүлээлгэн өгнө"

МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит болон дахин сонгуулийн томилолтын зардалд олгосон баримтын бүрдүүлэлтийг шалгахад сумдын сонгуулийн хорооны гишүүдийн Баянхонгор аймагт ажилласан албан томилолтын хуудсыг аймгийн сонгуулийн хорооны даргаар батлуулж дүгнүүлээгүй олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5<sup>12</sup>, 13.7<sup>13</sup> дэх заалт болон Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 12<sup>14</sup> дугаар зүйлд заасныг зөрчсөн байна. Иймд албан томилолтын хуудсыг баталгаажуулж, зөрчлийг арилгах зөвлөмжийг аймгийн сонгуулийн хорооны даргад хүргүүлэв.

СЕХ-ны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам”-ын 3.2<sup>15</sup> дахь заалт болон СЕХ-ны 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 260 тоот албан бичгээр ирүүлсэн “МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардлын тайлан, 2 дахь санал хураалтын зардлын тайланг тусад нь гаргах бөгөөд санхүүжилтийг хооронд нь гүйлгэх, зөвшөөрөлгүйгээр өөр зардалд зарцуулахыг хориглож байна” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

*МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн үед байгалийн гэнэтийн аюул, цаг агаарын нөхцөл байдлаас гол ус үерлэх, зам хаагдах, холбоо тасрах тохиолдолд онцгой байдлын үед зарцуулах болзошгүй зардалд 3,0 сая төгрөг хуваарилсан байхад тус зардлыг дахин сонгуулийн унааны зардалд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг ээлжит сонгуулийн зардлаар тайлагнасан;*

*Баянбулаг сум сонгуулийн зардлын тайланг бүрэн гаргаагүй, ээлжит сонгуулиар бичгийн хэргийн зардлыг 22,9 мянган төгрөгөөр хэтрүүлж, унааны зардлыг 22,9 мянган төгрөгөөр хэмнэж, эдгээр зардлыг хооронд нь гүйлгэн зарцуулсан;*

**2.2. Аймгийн сонгуулийн хороо хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс сумын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийн тайланг журамд заасны дагуу бүрэн хүлээн аваагүй, зарим сум тайланг хугацаа хоцроож ирүүлсэн байна.**

<sup>12</sup> “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”

<sup>13</sup> “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”

<sup>14</sup> “Албан томилолтын зардлын тооцоог ирснээсээ хойш ажлын 5 өдөрт багтаан гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнг албан томилолт олгосон удирдах дээд шатны байгууллага буюу албан тушаалтанд танилцуулан, томилолтын үнэмлэх дээрээ гарын үсэг зуруулж, томилолтоор ажилласан хугацааг батлуулан байр, уналгын хөлс төлсөн баримтыг бүрдүүлсний үндсэн дээр хийж дуусгана”

<sup>15</sup> “Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ”



Аймгийн сонгуулийн хорооны санхүүгийн ажилтан Э.Амарбаясгалан журмын СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 4.6<sup>16</sup> дахь заалтыг зөрчиж Эрдэнэцогт, Хүрээмарал, Баянцагаан, Галуут, Баацагаан, Баян-Овоо, Заг, Богд сумдаас бусад 12 сумын тайланг хүлээн аваагүй акт үйлдээгүй байна.

Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг СЕХ-ны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам”-ын 4.4<sup>17</sup>-т заасны дагуу Бөмбөгөр, Баянбулаг, Баян-Өндөр сум сонгуулийн тайлан, санхүүгийн баримтыг хугацаа хоцроож ирүүлсэн байна.

Сумдын сонгуулийн хороод сонгуулийн зардлын тайланг аймгийн сонгуулийн хороонд ирүүлэхдээ сонгуулийн зардлын тайлан өгөх тухай албан бичиг, тайлангийн товч танилцуулга тодруулга, баримт хүлээлгэн өгсөн актгүй байгаа нь СЕХ-ны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам”-ын 4.3<sup>18</sup> дэх заалтыг зөрчсөн бөгөөд бэлэн мөнгөний тайланг сумдууд огт гаргаагүй байна.

Аудитаар нийт 8683,7 мянган төгрөгийн алдааг илрүүлж, түүнийг залруулах зөвлөмжийг хүргүүлэв.

---

<sup>16</sup> “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нягтлан бодогч сум, дүүргийн сонгуулийн хорооноос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авч, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны санхүүгийн анхан шатны баримтын хамт архивын нэгж болгон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын архивт албан ёсоор хүлээлгэн өгнө”

<sup>17</sup> “Сум, дүүргийн сонгуулийн хорооны болон салбар комиссын дарга, нарийн бичгийн дарга нар 4.3-т заасан тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор гарган, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст ... хүлээлгэж өгнө”

<sup>18</sup> “Сум, дүүргийн сонгуулийн хороо болон салбар комиссын сонгуулийн зардлын тайлан дараахь хэсгээс бүрдэнэ:

4.3.1. Сонгуулийн зардлын тайлан өгөх тухай албан бичиг

4.3.2. тайлангийн товч танилцуулга, тодруулга

4.3.3. сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайлан

4.3.4. санхүүгийн анхан шатны баримтууд /хүлээлгэн өгсөн акт/”



## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Нийцлийн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн батлагдсан төсвийг зохих аргачлалын дагуу төлөвлөсөн эсэх асуудлыг аймгийн Сонгуулийн хорооны материалаас үзэх боломжгүй байна.

2. Сумдын сонгуулийн хороонд 10 төрлийн зардал хуваарилахаас 4 төрлийн зардлыг хуваарилалгүй аймгийн сонгуулийн хороо нэгдсэн журмаар олгож журмыг зөрчсөн байна.

3. Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардлын 2088,8 мянган төгрөгийн үлдэгдлийг журамд заасан хугацаанд СЕХ-д эргүүлэн төвлөрүүлээгүй, ээлжит сонгуулийн зардлаас дахин сонгуулийн зардалд 3,0 сая төгрөгийг гүйлгэн зарцуулж журмыг зөрчсөн байна.

4. Аймгийн сонгуулийн хороо хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс зардлын гүйцэтгэлийн тайланг буруу тайлагнасан байхад тайланг журамд заасны дагуу бүрэн хүлээн аваагүй, зарим сум тайланг хугацаа хоцроож ирүүлсэн байна.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

2017.08.01

Баянхонгор сум

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн сонгуулийн хорооны дарга Ц.Дашцэрэнд зөвлөж байна. Үүнд:

1. Баянхонгор аймагт МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг зохион байгуулах зардлын үлдэгдэл 2088,8 мянга, дахин сонгуулийг зохион байгуулах зардлын үлдэгдэл 5707,6 мянган төгрөгийг СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолын дагуу СЕХ-ны дансанд төвлөрүүлэх.

2. Аймгийн сонгуулийн хорооны санхүүгийн ажилтны СЕХ-д сонгуулийн зардлын тайлан хүлээлгэж өгөх зардлын 711,0 мянган төгрөгийн зарцуулалтын баримтыг санхүүгийн баримтанд бүрдүүлж, томилолтын хуудсыг баталгаажуулаагүй зөрчил, хоолны суутгалын ХХОАТ-ын 28,0 мянган төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлж, шатахууны зардалд анхан шатны баримтгүй олгосон 148,3 мянган төгрөгийг нөхөн төлж зөрчлийг арилгах.

Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2017 оны 08 дугаар сарын 15-ны дотор аймгийн Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ